

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255011>

СУРАЛЦАГЧИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ БА МОНГОЛ ХЭЛНИЙ
СУРЛАГЫН АМЖИЛТЫН ХАМААРАЛ:
(НИЙГЭМ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ҮҮДНЭЭС)

Д.Энхжаргал
Ц.Батдорж

Хураангуй: Энэхүү судалгаанд суралцагчийн өөрийн үнэлгээ нь монгол хэлний сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйг нийгэм хэл шинжлэлийн үүднээс авч үзэв. Уламжлалт боловсрол судлалын хүрээнд өөрийн үнэлгээг сэтгэл зүйн болон сургалтын хүчин зүйлтэй холбон тайлбарладаг бол энэхүү өгүүлэлд суралцагчийн хэлний орчин, хэлний хэрэглээ, харилцааны оролцоо, хэлний капитал зэрэг нийгэм-хэл шинжлэлийн хүчин зүйлтэй хамтатган авч үзсэнээрээ онцлог юм.

Судалгаанд Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 38575 сурагчийг хамруулж, асуулга болон хоёрдогч өгөгдөлд тулгуурлан SPSS 22 программ ашиглан дүн шинжилгээ хийв. Үр дүнгээс харахад сурагчдын мэдээлэлтэй ажиллах чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, хичээлд оролцох идэвх, багаар ажиллах чадвар зэрэг нь өөрийн үнэлгээтэй нягт уялдаж, улмаар сурлагын амжилтад эерэг нөлөө үзүүлж байна. Мөн эдгээр чадварууд нь зөвхөн хувь хүний чадвар бус, суралцагчийн хэлний орчин, нийгмийн харилцаанд оролцох түвшинтэй шууд холбоотой болох нь тогтоогдов. Энэхүү судалгаа нь монгол хэлний боловсролын чанарыг зөвхөн сургалтын үр дүнгээр бус, хэлний нийгмийн нөхцөл, харилцааны оролцоо, хэлний нөөцтэй холбон авч үзэх шаардлагатайг нотлон харуулав.

Түлхүүр үг: өөрийн үнэлгээ, хэлний капитал, нийгэм хэл шинжлэл, монгол хэлний боловсрол

Keywords: self-evaluation, linguistic capital, sociolinguistics, Mongolian language education

1. Удиртгал. Боловсролын чанарыг тодорхойлох судалгаанд уламжлалт байдлаар сурагчийн мэдлэг, чадвар, сургалтын арга зүй, үнэлгээний тогтолцоог голлон авч үздэг. Гэвч сүүлийн үеийн судалгаанд суралцах үйл явцыг зөвхөн хувь хүний танин мэдэхүйн түвшинд бус, нийгмийн харилцаа, хэлний хэрэглээ, соёлын орчинтой уялдуулан авч үзэх хандлага эрчимжиж байна.

Нийгэм хэл шинжлэлийн судалгаанд хэл нь зөвхөн мэдээлэл дамжуулах хэрэгсэл бус, нийгмийн байр суурь, соёлын үнэлэмж, эрх мэдлийн илэрхийлэл гэж үздэг. Пьер Бурдьё (Pierre Bourdieu, 1991)-гийн хэлний капиталын онолоор хувь хүний хэлний хэрэглээ нь түүний нийгмийн орчин, боловсролын боломжтой нягт холбоотой байдаг бол Делл Хаймс (Dell Hymes, 1972) харилцааны чадамжийг нийгмийн нөхцөлд тохируулан хэл ашиглах чадвар гэж тодорхойлсон. Мөн Байзил Бёрнстейн (Basil Bernstein, 1971)-ий хэлний кодын онол нь суралцагчдын хэлний орчин, нийгмийн гарал нь боловсролын амжилтад нөлөөлдөг болохыг харуулсан байдаг. Эдгээр онолын үүднээс үзвэл суралцагчийн өөрийн үнэлгээг зөвхөн сэтгэл зүйн үзэгдэл хэмээн хязгаарлах бус, харин тэдний хэлний орчин, нийгмийн

харилцаанд оролцох байдал, хэлний нөөцтэй холбон судлах боломжтой байна. Тиймээс бид, дээрх онолуудыг үндэс болгон сурагчдын өөрийн үнэлгээ хийгээд гүйцэтгэлийн үзүүлэлтийг уялдуулан судалж, монгол хэлний сурлагын амжилтад нөлөөлж буй хэлний нийгмийн хүчин зүйлсийг тодруулахыг зорив.


2. Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй. Монгол Улсын хэмжээнд монгол хэлний хичээлийн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрхэн эзэмшсэн байгааг тандах зорилготой чанарын үнэлгээний судалгааг БШУЯ-ны харьяа Боловсролын үнэлгээний төвөөс 2014 оноос эхлэн зохион байгуулсан бөгөөд тус өгүүлэлд 2019 оны суурь боловсрол эзэмшигчдийн судалгаан дээр үндэслэв. Ингэхдээ тоон болон чанарын судалгааны хосолсон арга зүйг ашиглав. Анхдагч өгөгдлийг асуулга, ярилцлагаар, хоёрдогч өгөгдлийг Боловсролын үнэлгээний төвийн тайлангаас авав.

Анхдагч өгөгдлийн хүрээнд нийт 38575 сурагчийг хамруулсан бөгөөд Улаанбаатар хот, орон нутгийн сурагчдыг хамруулав. Судалгааны өгөгдлийг SPSS 22 программ ашиглан боловсруулж, ANOVA шинжилгээ хийв. Асуулгын хүрээнд дараах үндсэн хувьсагчдыг авч үзсэн бөгөөд эдгээрийг сурагчдын өөрийн үнэлгээ болон сурлагын амжилттай харьцуулан судлав. Үүнд:

- мэдээлэлтэй ажиллах чадвар
- асуудал шийдвэрлэх чадвар
- хичээлд оролцох идэвх
- багаар ажиллах чадвар

3. Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг. 2015 оноос чанарын үнэлгээний судалгаанд хамрагдсан ЕБС-ийн сургуулийн суралцагчдын судалгааны үр дүн буюу гүйцэтгэлийн өсөлт бууралтыг *Зураг 1*-г харуулав.

2015-2018 онд чанарын үнэлгээний судалгаанд хамрагдсан суралцагчдыг түүврийн аргаар (2321-4282 суралцагч) сонгосон бол 2019 онд үндэсний хэмжээнд суурь боловсрол эзэмшиж буй бүх суралцагчийг (38757) судалгаанд хамруулав.



Зураг 1. Гүйцэтгэлийн дундаж (хувиар)

2019 онд судалгаанд оролцогчдын 49.3 хувь нь эрэгтэй, 50.7 хувь нь эмэгтэй суралцагч байсан. Мөн нийт оролцогчдын 41 хувь нь Улаанбаатар хотынх, 59 хувь нь орон нутгийн суралцагчид байна. Сургуулийн өмчийн хэлбэрээр нь авч үзвэл,


94.5 хувь нь төрийн өмчийн, 5.5 хувь нь төрийн бус өмчийн сургуулиуд, мөн сургуулийн байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотын 15861, аймгийн төвийн 10481, сумын төвийн 12105, багийн төвийн 310 суралцагч хамрагджээ.

Судалгаанд хамрагдсан суралцагчдыг газар зүйн байршлаар нь ангилан үзвэл, төвийн бүс 16.5, баруун бүс 15.8, зүүн бүс 7.7, хангайн бүс 19.6, Улаанбаатар хотынх 40.4 хувийг тус тус эзэлж байна. 2019 оны чанарын үнэлгээний судалгааны гүйцэтгэлийн дунджийг 2018 оны судалгааны үр дүнтэй /49.4 хувь/ харьцуулахад 1.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Анхны онооны интервал

| Суралцагчдын тоо | 0-19 | 20-29 | 30-39 | 40-49 | 50-59 | 60-69 | 70-79 | 80-89 | 90-100 |
|------------------|------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|
| Орон нутаг | 2672 | 1833 | 2499 | 3407 | 4132 | 4178 | 2836 | 1149 | 190 |
| Эзлэх хувь | 6.9 | 4.7 | 6.4 | 8.8 | 10.7 | 10.8 | 7.3 | 3.0 | 0.5 |
| Улаанбаатар | 1138 | 1001 | 1519 | 2180 | 2986 | 3211 | 2624 | 1034 | 168 |
| Эзлэх хувь | 2.9 | 2.6 | 3.9 | 5.6 | 7.7 | 8.3 | 6.8 | 2.7 | 0.4 |
| Нийт | 3810 | 2834 | 4018 | 5587 | 7118 | 7389 | 5460 | 2183 | 358 |

Дээрх хүснэгтээс харахад, 40-69 онооны завсарт хамгийн олон шалгуулагч, 20-29, 90-100 онооны завсар хамгийн бага шалгуулагчтай байна. Үүнтэй уялдан онооны тархалтын муруй дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:



Зураг 2. Гүйцэтгэлийн хувийн тархалт

Гүйцэтгэлийн хувийн тархалтыг хэвийн тархалтын графиктай харьцуулсан зургаас харахад, онооны тархалтын муруй эерэг хэлбийлттэй гарсан бөгөөд суралцагчдын ихэнх нь 40-69 хооронд оноо авсан байна. Монгол хэлний хичээлийн тухайд 2019 оны гүйцэтгэлийн хувь өмнөх онтой харьцуулахад өссөн хэдий ч төрөлх хэлний хувьд үүнээс (50.5 улсын дундаж) илүү амжилтыг үзүүлэх шаардлагатай, мөн боломжтой гэж үзэж байгаад судалгааны үр дүн оршино. 2015 оны гүйцэтгэлийнхувь 66.5 хувь байгаагаас харахад, 70 хувь хүрэх боломж, нөхцөл байгааг илтгэнэ.

Судалгаанд оролцогч суралцагчдаас нийт 54 асуултаар асуулга авсан бөгөөд судалгааны үр дүнг SPSS 22 программаар шинжилж үзэхэд, дараах асуулгууд статистик ач холбогдолтой байна. Сурлагын амжилт өндөр байна гэдэг шалгуурыг 2019 оны чанарын үнэлгээний судалгааны монгол хэлний хичээлийн улсын дундажтай (50.5 хувьтай) харьцуулан авч үзсэн болно.

Хүснэгт 2. Мэдээлэлтэй ажиллах чадвар (Гүйцэтгэлийн хувиар)

| Та мэдээлэлтэй ажиллах өөрийн чадвараа үнэлнэ үү. | Гүйцэтгэлийн дундаж | | | | | Anova шинжүүр | |
|---|---------------------|------|------|-----|--------|---------------|----------|
| | машсайн | сайн | дунд | муу | машмуу | | |
| Мэдээллийг цуглуулах аргаа сонгох | 55 | 54 | 47 | 42 | 34 | $F=369.5$ | $P<.000$ |
| Мэдээлэл цуглуулах, төлөвлөх | 57 | 54 | 48 | 42 | 31 | $F=490.9$ | $P<.000$ |
| Мэдээлэл боловсруулах, бусдад танилцуулах | 57 | 54 | 49 | 44 | 39 | $F=412.0$ | $P<.000$ |
| Мэдээллийг хэрэглэх, тайлбарлах | 56 | 54 | 48 | 15 | 42 | $F=388.1$ | $P<.000$ |

Дээрх үр дүнгээс харахад мэдээлэл цуглуулах, төлөвлөх, мэдээлэл боловсруулах, бусдад танилцуулах чадвараа маш сайн гэж хариулсан суралцагчдын сурлагын амжилт өндөр байна.

Хүснэгт 3. Асуудал шийдвэрлэх чадвар (Гүйцэтгэлийн хувиар)

| Та өөрийн асуудал шийдвэрлэх чадвараа үнэлнэ үү. | Гүйцэтгэлийн дундаж | | | | | Anova шинжүүр | |
|--|---------------------|------|------|-----|---------|---------------|----------|
| | машсайн | сайн | дунд | муу | маш муу | | |
| Асуулт гаргаж, асуудлаа тодруулах | 55 | 54 | 48 | 45 | 43 | $F=320.8$ | $P<.000$ |
| Асуудлынхаа учир шалтгааныг илрүүлэх | 56 | 54 | 48 | 45 | 41 | $F=354.0$ | $P<.000$ |
| Асуудлаа шийдвэрлэх | 54 | 53 | 50 | 47 | 46 | $F=338.7$ | $P<.000$ |
| Асуудлаа дэвшүүлэх, үр дүнг үнэлэх | 55 | 54 | 49 | 45 | 42 | $F=403.6$ | $P<.000$ |

Асуулт гаргаж, асуудлаа тодруулах чадвараа маш сайн гэж 15.8 хувь нь, сайн гэж 41.9 хувь нь дунд гэж 23.9 хувь нь, муу гэж 2.6 хувь нь, маш муу гэж 0.2 хувь нь, огт хариулаагүй суралцагч 15.6 хувийг эзэлж байна.

Асуудлын учир шалтгааныг илрүүлэх чадвараа маш сайн гэж 16.9 хувь нь, сайн гэж 42.2 хувь нь дунд гэж 22.2 хувь нь, муу гэж 2.6 хувь нь, маш муу гэж 0.2 хувь нь, 15.9 хувь нь огт хариулаагүй байна.

Асуудал шийдвэрлэх чадвараа маш сайн гэж 17.5 хувь нь, сайн гэж 41.4 хувь нь дунд гэж 22.2 хувь нь, муу гэж 2.6 хувь нь, маш муу гэж 0.2 хувь нь, 16.1 хувь нь огт хариулаагүй байна.

Асуудлаа дэвшүүлэх, үр дүнг үнэлэх чадвараа маш сайн гэж 15.8 хувь нь, сайн гэж 38.5 хувь нь дунд гэж 25.7 хувь нь, муу гэж 3.6 хувь нь, маш муу гэж 0.4 хувь нь, огт хариулаагүй нь 16 хувийг эзэлж байна.

Дээрх үр дүнгээс харахад асуудлын учир шалтгааныг илрүүлэх чадвараа маш сайн гэж хариулсан суралцагчдын сурлагын амжилт хамгийн өндөр байна.

Хүснэгт 4. Хичээлд оролцох байдал (Гүйцэтгэлийн хувиар)

| Та өөрийн хичээлд оролцох байдлаа үнэлнэ үү. | Гүйцэтгэлийн дундаж | | | | | Anova шинжүүр | |
|--|---------------------|------|------|-----|--------|---------------|--------|
| | Машсайн | сайн | дунд | муу | машмуу | | |
| Сонирхон судлах байдал | 55 | 52 | 47 | 46 | 40 | F=377.2 | P<.000 |
| Санаачилгатай байдал | 56 | 53 | 49 | 45 | 42 | F=329.4 | P<.000 |
| Бүтээлч байдал | 55 | 53 | 49 | 45 | 39 | F=329.4 | P<.000 |

Дээрх дүнгээс харахад хичээлээ сонирхон судлах байдлаа маш сайн буюу сайн гэж хариулсан суралцагчдын сурлагын амжилт өндөр байх бөгөөд хичээлдээ санаачилгатай оролцдог байдлаа маш сайн буюу сайн гэж хариулсан суралцагчдын сурлагын амжилт өндөр байна.

Мөн хичээлдээ бүтээлчээр оролцдог байдлаа маш сайн буюу сайн гэж хариулсан суралцагчдын сурлагын амжилт өндөр байна.

Хүснэгт 5. Багаар ажиллах чадвар

| Та өөрийн “багаар ажиллах” чадвараа үнэлнэ үү. | Гүйцэтгэлийн дундаж | | | | | Anova шинжүүр | |
|--|---------------------|------|------|-----|--------|---------------|--------|
| | машсайн | сайн | дунд | муу | машмуу | | |
| Би багийн ажилд оролцдог | 57 | 51 | 46 | 43 | 39 | F=422.5 | P<.000 |
| Би багийн бусад гишүүдтэйгээ санаабодлоо чөлөөтэй солилцдог | 57 | 52 | 46 | 42 | 42 | F=570.0 | P<.000 |
| Би багийн гишүүдийн саналд хүндэтгэлтэй хандаж, зөвшилцөхийг эрмэлздэг | 57 | 53 | 46 | 40 | 43 | F=564.1 | P<.000 |

| | | | | | | | |
|--|----|----|----|----|----|---------|--------|
| Би багийн гишүүдээс гараагүй өөр үзэл бодол, санааг дэвшүүлдэг | 56 | 54 | 49 | 42 | 37 | F=394.8 | P<.000 |
| <i>Би багийн хамтын шийдвэр гаргахад идэвхтэй оролцдог</i> | 56 | 52 | 46 | 42 | 35 | F=447.7 | P<.000 |

Багийн ажилд оролцохдоо маш сайн гэж 30.1 хувь нь, сайн гэж 39.3 хувь нь, дунд гэж 14.4 хувь нь, муу гэж 1.7 хувь нь, маш муу гэж 0.2 хувь нь, огт хариулаагүй нь 14.3 хувийг эзэлж байна.

Багийн бусад гишүүдтэйгээ санаа бодлоо маш сайн солилцдог гэж 30.8 хувь нь, сайн гэж 35.9 хувь нь, дунд гэж 15.8 хувь нь, муу гэж 2.4 хувь нь, маш муу гэж 0.3 хувь нь, огт хариулаагүй нь 14.8 хувийг эзэлж байна.

Би багийн гишүүдийн саналд хүндэтгэлтэй хандаж, зөвшилцөхдөө маш сайн гэж 25.8 хувь нь, сайн гэж 40 хувь нь, дунд гэж 16.9 хувь нь, муу гэж 1.8 хувь нь, маш муу гэж 0.3 хувь нь, огт хариулаагүй нь 15.2 хувийг эзэлж байна.

Би багийн гишүүдээс гараагүй өөр үзэл бодол, санааг дэвшүүлэхдээ маш сайн гэж 19.2 хувь нь, сайн гэж 38.4 хувь нь, дунд гэж 23.5 хувь нь, муу гэж 3 хувь нь, маш муу гэж 0.4 хувь нь, огт хариулаагүй нь 15.5 хувийг эзэлж байна.

Би багийн хамтын шийдвэр гаргахдаа маш сайн гэж 31.4 хувь нь, сайн гэж 37.6 хувь нь, дунд гэж 13.7 хувь нь, муу гэж 1.8 хувь нь, маш муу гэж 0.4 хувь нь, огт хариулаагүй нь 15.1 хувийг эзэлж байна.

Дээрх үр дүнгүүдийг нэгтгэн үзвэл дараах онцлогууд илэрч байна. Үүнд:

Нэгдүгээрт, суралцагчийн өөрийн үнэлгээ нь зөвхөн хувь хүний сэтгэл зүйн үзүүлэлт бус, харин хэлний капиталын илэрхийлэл байна. Өөрөөр хэлбэл, өөрийн чадвараа өндөр үнэлж буй суралцагчид ихэвчлэн харилцаанд идэвхтэй оролцдог, хэлний хэрэглээгээр илүү өргөн байна.

Хоёрдугаарт, хичээлд оролцох идэвх болон багаар ажиллах чадвар нь харилцааны чадамжийн бодит илрэл бөгөөд эдгээр чадвар өндөр байх тусам сурлагын амжилт өндөр байна.

Гуравдугаарт, хэлний орчин буюу хот, хөдөөгийн ялгаа, сургуулийн нөхцөл нь суралцагчийн өөрийн үнэлгээ болон сурлагын амжилтад нөлөөлж байна. Энэ нь хэлний кодын онолтой нийцэж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар суралцагчийн өөрийн үнэлгээ болон монгол хэлний сурлагын амжилтын хооронд статистик ач холбогдол бүхий хамаарал байгааг тогтоолоо. Судалгааны үр дүнгээс үзэхэд мэдээлэлтэй ажиллах чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, хичээлд оролцох идэвх, багаар ажиллах чадвар зэрэг үзүүлэлтүүдийг өндрөөр үнэлсэн суралцагчдын сурлагын гүйцэтгэл илүү өндөр байна.

Нийгэм хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл, эдгээр чадварууд нь зөвхөн хувь хүний танин мэдэхүйн түвшинг илэрхийлэх бус, харин суралцагчийн хэлний орчин, харилцаанд оролцох түвшин, хэлний нөөц буюу хэлний капиталын илрэл юм. Иймд өөрийн үнэлгээг суралцагчийн нийгмийн орчинд эзлэх байр суурь, хэлний хэрэглээний идэвх, харилцааны чадамжтай салшгүй холбоотой үзүүлэлт гэж үзэх үндэслэл бүрдэж байна.

Тус судалгааны үр дүн нь хот хийгээд орон нутгийн ялгаа болон сургуулийн байршил зэрэг нийгмийн хүчин зүйлс суралцагчдын сурлагын амжилтад тодорхой хэмжээгээр нөлөөлж байгааг харууллаа. Энэ нь хэлний орчин, боловсролын нөөцийн ялгаа суралцах үр дүнд нөлөөлдөг тухай нийгэм хэл шинжлэлийн онолуудтай нийцэж байна.

Монгол хэлний боловсролын чанарыг зөвхөн сургалтын агуулга, арга зүйгээр хязгаарлах бус, суралцагчийн хэлний орчин, харилцааны боломж, хэлний капиталын хөгжлийг хамтатган авч үзэх шаардлагатай байна.

Ном зүй

- Боловсролын үнэлгээний төв. (2019). *Чанарын үнэлгээний судалгааны тайлан*. Улаанбаатар.
- Бэгз, Н., Жадамба, Н., Лхагвасүрэн, П., & Итгэл, М. (2019). Монголын боловсролын судалгааны хөгжлийн асуудалд. *Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг*, 24, 6–23.
- Итгэл, М., Отгонбаатар, Х., Санжаабадам, С., Туяа, У., Энхжаргал, Х., & Дэнсмаа, Ж. (2024). Монгол улсын боловсролыг тогтвортой хөгжүүлэх үзэл санаа. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 29(2).
- Andrade, Heidi L.. (2019). *A critical review of research on student self-assessment*. *Frontiers in Education*, 4(87), 1–13. <https://doi.org/10.3389/feduc.2019.00087>
- Bourdieu, Pierre. (1991). *Language and symbolic power*. Harvard University Press.
- Bernstein, Basil. (1971). *Class, codes and control: Vol. 1. Theoretical studies towards a sociology of language*. Routledge.
- Flavell, John H.. (1979). Metacognition and cognitive monitoring. *American Psychologist*, 34(10), 906–911.
- Hymes, Dell. (1972). On communicative competence. In J. B. Pride & J. Holmes (Eds.), *Sociolinguistics* (pp. 269–293). Penguin.
- Labov, William. (1972). *Sociolinguistic patterns*. University of Pennsylvania Press.
- McMillan, James H., & Hearn, Jessica. (2008). Student self-assessment: The key to stronger student motivation and higher achievement. *Educational Horizons*, 87(1), 40–49.
- Panadero, Ernesto., & Alonso-Tapia, Jesús. (2013). Self-assessment: Theoretical and practical connotations. *Electronic Journal of Research in Educational Psychology*, 11(2), 551–576.
- Sadler, D. Royce. (1989). Formative assessment and the design of instructional systems. *Instructional Science*, 18(2), 119–144.
- Weimer, M. (2002). *Learner-centered teaching: Five key changes to practice*. Jossey-Bass.

Abstract

This study examines how students' self-assessment influences their academic achievement in Mongolian language from a sociolinguistic perspective. While traditional educational research typically interprets self-assessment in relation to psychological and instructional factors, this article is distinguished by its integration of sociolinguistic factors such as learners' linguistic environment, language use, participation in communication, and linguistic capital.

The study involved a total of 38,575 students from Ulaanbaatar and rural areas. Based on survey data and secondary data, the analysis was conducted using SPSS 22. The results indicate that students' abilities in information processing, problem-solving, classroom participation, and teamwork are closely associated with their self-assessment and, consequently, have a positive impact on their academic achievement. Furthermore, these abilities are not merely individual competencies but are directly related to learners' linguistic environment and their level of participation in social interactions.

The findings demonstrate that the quality of Mongolian language education should not be evaluated solely based on learning outcomes; rather, it must also be considered in relation to social linguistic conditions, communicative participation, and linguistic resources.